

ТҮҮХ, СОЁЛ

М. Дулам

**ХЯТАДЫН ТҮҮХЧИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН ЗАРИМ
БҮТЭЭЛД МОНГОЛЫН ТҮҮХИЙГ ГУЙВУУЛЖ БАЙГАА НЬ**

Газар нутгийн өнгөлзлөг бол Бээжингийн эрх баригчдын их гүрний дээрэнгүй бодлогын нэг гол хэсэг мөн. Тэд сүүлийн 20 гаруй жилийн турш БНХАУ-тай хил залгадаг бараг бүх орны нутаг дэвсгэрт өнгөлзөж барагцаалахад 3,2 сая ам км буюу БНХАУ-ын бүх нутгийн гуравны нэгээс багагүй нутгийг бусад орнуудаас тасдан авч нэгтгэхийн тул газрын зураг зүйн түрэмгийллээс эхлэн хүч хэрэглэх хүртэл янз бүрийн явууллага хийж түүнийгээ түүхэн үндэстэй болгохын тул археологи, түүх судлалыг ихэд ашиглаж байна. Тэд өөрсдийн эл явууллагад Хятад ба гадаадын олон нийтийг үнэмшүүлэх мөн тэднээр дэмжүүлэх зорилгоор энд тэндгүй археологийн олдворын үзэсгэлэн гэгчийг гарган ажиллуулах, түүхийн аль нэгэн үед хятадын «алдсан нутаг» гэгчийн тухай өгүүлсэн ном, товхимол, өгүүлэл олныг нийтлэн тарааж байна.

Хятадын эрх баригчдаас БНМАУ-ын хувьд явуулж буй бодлого бол тэднээс дэлхий дахиныг ноёрхох тэгэхдээ юуны урьд социалист ертөнцийг мөхөөх гэсэн их гүрний дээрэнгүй санаархлын нэг хэсэг болж байна. БНМАУ-ын засгийн газраас 1978 оны 4-р сарын 12-нд БНХАУ-ын засгийн газарт өгсөн нотод «БНХАУ-ын удирдах бүлгийнхэн БНМАУ-ыг Хятадад нэгтгэн авах санаархлаа нэг биш удаа илтээр мэдэгдэж байсан төдийгүй, түүнийгээ практик алхмаар лавшруулж байсан нь яван явсаар хоёр орны харилцааг одоогийн хурцадмал байдалд хүргэсэн юм» гэж тодорхойлсон билээ. Тэгвэл Маогийнхан өөрсдийн түрэмгий зорилгын үүднээс монголын түүхийн олон асуудлыг мушгин гуйвуулж байгаагийн дотроос Монголын төрийн тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийн уламжлал, БНМАУ-ын социалист бүтээн байгуулалт, Монгол-Зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагаа зэрэг чухал асуудлыг хэрхэн гүтгэн гуйвуулж байгаагийн сүүлийн үеийн нилээд томруун баримтын тухай өгүүлсүгэй.

I

Манай эриний өмнөх III зууны үед Монгол нутагт Хүннү хэмээх анхны улс үүсч, Монголын төрийн тусгаар тогтнол эхэлсэн билээ. 1974 онд ХКН-ын төв хэвлэлүүдэд Хүннү улсыг Хятадын Хан улсын нэгэн хэсэг байсан мэтээр түүхийг зориуд гуйвуулж бичсэнийг манай эрдэм шинжилгээний зарим хэвлэлд шүүмжилж Хүннү улс Хятадын Хан улсын хэсэг байгаагүй, харин Хан улс Хүннүтэй хил хязгаарын заагаа Цагаан хэрмээр тогтоож байсныг түүхэн сурвалж бичгийн баримтаар нотолсон билээ¹ Бас Ши Да гэгчийн бичсэн «Хаант орос Хятадыг түрэмгийлсний товч түүх»* гэдэг товхимол 1976 онд Бээжинд хэвлэгдэн гарчээ. Үүний зохиогч одоогийн Хятадын их гүрний дээрэнгүй үзэлт эрх баригчдаас ЗХУ болон БНМАУ-ын халдашгүй дархан нутаг дэвсгэрт шунахайран буй ямар ч

1 Г. Сүхбаатар, Хүннү Хятадын харилцаа ба маоизм-«Маоизм, Маогийнхан», УБ., 1975. № 2. 26—37-р талд.

*Ши Да. Шаэ цинь хуа цзяньши, 1976. Бээжин.

үндэсгүй өнгөлзлөгийг «түүхийн үндэслэлтэй» болгох гэсэн оролдлого хийсэн нь уг номын агуулгаас илэрхий байна. Хаант Орос улс Хятадаас 1,5 сая гаруй ам км нутаг түрэмгийлэн эзэлсэн нь одоо ЗХУ-ын нутаг болоод байгаа юм гэдэг ойлгоцыг уншигчдад өгөхийн тулд зохиогч эс бусын мэдээ сэлт тоочжээ. Тэгэхдээ эрт урьд цагт Хятадын эзэн хааны аль нэг элч, цэрэг, хятад худалдаачны явж өнгөрсөн буюу түр хэргээр очиж байсан нутаг орон, тэр ч байтугай хятадын хувьд харь угсаатан Монгол, Манжийн феодалын байлдан дагуулагчдын түрэмгийлэлд ямар нэгэн хэмжээгээр өртсөн нутаг бүхнийг Хятадын гэж үзсэн нь нэн инээдэмтэй.

Хятадын эрх баригчид 60-аад оноос ЗХУ-ын дархан нутаг дэвсгэрт илэрхий өнгөлзөж, хятад-зөвлөлтийн хил дээр зэвсэгт өдөөн хатгалга хүртэл хийх болсон билээ. Түүнтэй холбогдуулан ЗХУ-ын засгийн газраас 1969 оны 6-р сарын 13-нд гаргасан мэдэгдэлдээ: «Зөвлөлт Холбоот Улс, Хятад улсын хооронд үнэн хэрэг дээрээ нутаг дэвсгэрийн маргаантай асуудал огт байхгүй» гэж няцаасан билээ.

Ши Да товхимолдоо: «Говиос хойших Гадаад Монголын район бол түүхнээсээ манай улсын зарим нүүдэлчин малчид оршин амьдардаг нутаг юм. XIII зууны үед монгол угсааны язгууртнууд тэндээс Хятадад нэвтрэн ноёрхож Хятадын Юан улсыг байгуулсан...» (13 дахь талд) гэжээ.

Манай нутаг дээр анхны хүй нэгдлийн хуучин чулууны үед буюу 400-300 мянган жилийн тэртээ ууган нутгийн хүн амьдарч байсныг орчин үеийн түүхийн шинжлэх ухаан бүрэн нотолж байгаа юм. Монгол нутагт тогтсон анхны улс Хүннүгээс хойш ч гэсэн манай нутаг дээр монгол, түрэг угсааны хэдэн улс дараалан мандаж мөхөж байсан, тэр бүхнийг хятадын «нүүдэлчин малчид» байсан гэх нь яавч түүхэн үнэнд нийцэхгүй. Харин Хятадтай янз бүрийн хэлбэрээр харилцаж байсан хөрш аймаг улс байсан гэвэл өөр хэрэг юм.

XIII зууны эхээр монгол нутагт тухайлбал одоогийн манай нутаг Онон мөрний хөвөөн дээр Монголын нэгдмэл хаант улс байгуулагдсаны дараа Монгол угсааны язгууртнууд хөрш орнуудаа түрэмгийлэн эзэлсэний дүнд монголын эзэнт гүрэн биеэ даасан байдалтай хэдэн улс болсны нэг нь Монгол, Хятад, Төвд зэрэг орныг хүчээр захирсан Юан улс байв. Харин түүний нийслэл нь Хархорумаас одоогийн Бээжинд шилжиж хятад, нутагт төвлөж байсан нь үнэн. Гэхдээ Юан улс бол ганц Хятадын төр байгаагүй нь илэрхий билээ. Ийм ч учраас тэр төр эцсийн эцэст хятадын ард түмний шударга тэмцэлд ялагдаж, монгол нутагтаа шилжсэнээр Монгол, Хятадын хил дахин Цагаан хэрмээр тогтоогдсон нь түүхэн сурвалжид тодорхой бий.

Хятадын маоист түүхчид, Монголын Юан улсын ноёрхол Хятадад мөхсөний дараа ч гэсэн Монгол орон Хятадын хэсэг байсан мэтээр бичиж байна. Нэн ялангуяа баруун монгол буюу Ойрадын түүхийг элдвээр завхруулсан өгүүллүүд хятадын эрдэм шинжилгээ, улс төр-онолын сэтгүүлүүдэд байн байн гарч байна.

Эдгээр өгүүллийг бичигчид түүхэн баримтыг гуйвуулж Монголыг Хятадын хэсэг байсан гэж нотлохыг оролдож байгаа төдийгүй, харин Юан улсын ноёрхол Хятадад унасны дараа нэг талаас Монголын хаан ноёд Хятадыг дахин ноёрхох нөгөө талаас Хятадын Мин улсын эрх баригчид Монголыг өөрийн захиргаанд оруулахын тулд харилцан байн байн дайтаж байсныг нэгэн улсын дотор болж байсан «ангийн тэмцэл» мэтээр дүрслэжээ. Тухайлбал: «Лиши яньцзю» (түүх судлал) сэтгүүлийн 1976 оны 2-рт нийтлүүлсэн «Худал үг түүхийг өөрчилж чадахгүй» гэдэг өгүүлэлд «Монгол угсаатны нэг хэсэг болох Ойрад аймаг бол Юан улсын

үеэс манай нэгдмэл олон үндэстний улсын гишүүн болсон юм» гээд 1449 онд тайш Эсэн тэргүүтэй монголын цэрэг, Ин Цзун хаан тэргүүтэй Хятад Мин улсын цэргийн хооронд дайн болж Ин Цзун хаан эхний тулалдаанаар монголын цэрэгт олзлогдож байсныг дурдахдаа: «...Эсэн нэгэн удаа бослого гаргаж, Мин улсын Ин Цзун хааныг барьж авав» гэж бичжээ.

Түүхийн хөдлөшгүй баримтаас үзэхэд Мин улсын цэрэг хэдэн удаа Монгол орны гүн рүү цэрэглэн цөмөрч байсан боловч баруун, зүүн монголын алиныг ч эрхшээлдээ оруулж чадаагүй бөгөөд харин Монголын нэг хэсгийг нөгөө рүү нь тухирч хямралдуулах бодлого явуулахын сацуу хойт хил Цагаан хэрмийн хавиа сүрхий бэхлэж байсан нь илэрхий. Ийм ч учраас хятадууд XVII зууны үед бичсэн «Минши» (Мин улсын түүх) гэдэг төрийн албан түүхэндээ Ойрад, Зүүн Монгол (татар) хоёрыг гадаад улсын бүлэгт оруулж бичсэн байдаг. Ер нь Юан улсын ноёрхол, Хятадад мөхөсөний дараа Монгол улсын төрийн төв эх нутагтаа шилжиж, Хятадын Мин улстай элч солилцох, хилийн худалдаа хийх, дайтах, найрамдах гэх зэрэг харилцаатай байсан нь нэгэн улсын дотоод дахь харилцаа огт биш байсан гэдгийг хятад сурвалж бичгээс тодорхой мэдэж болно.

Маогийнхан түүхэн үнэнийг хайхрахгүй, гагцхүү өөрсдийн баримталж буй улс төрийн бодлогын үүднээс Монголын төрийн тусгаар тогтнолыг зориуд үгүйсгэж, түүнээсээ үндэслэн монголын түүхийн олон асуудлыг дураараа гуйвуулж байна.

I

XVII зууны эхээр Манжийн цэрэг-феодалын улс үүсч, эхлээд Монголын өмнөд хэсэг буюу Өвөр Монголыг, дараа нь Хятадын Мин улсыг тус тус эзлэж улмаар XVII зууны эцсээр Ар Монголыг байлдан дагуулсан билээ. Тэгэхэд Баруун Монгол буюу Ойрад нь Монголын тусгаар тогтнолын сүүлчийн голомт болон үлдээд XVI зууны сүүлчийн хагас хүртэл Манжийн байлдан дагуулагчдын эсрэг цуцалтгүй тэмцэж байсан юм. Гэтэл маогийнхан Монголын биеэ даасан төрийн уламжлалыг үгүйсгэхийн зэрэгцээгээр монголчууд үндэснийхээ эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө харийн түрэмгийлэгчдийг эсэргүүцэн тэмцсэн баатарлаг түүхийг гуйвуулж үгүйсгэхийг оролдож байна.

Тэд юуны урьд манж нар Монголыг байлдан дагуулаагүй, харин Мин улсын харъяанд байсан Монгол орны энд тэнд гарсан үймээнийг төвшитгөж байсан гэх ба мөн үймээн нь цөм Хаант Оросын тухиралтаар гарч байсан гэж нотлохыг оролдсоор байна. Энэхүү үндэсгүй оролдлогыг манай эрдэмтэд түүхийн үүднээс шүүмжлэн няцааж байсан билээ*. «Лиши яньцзю» сэтгүүлийн 1976 оны 2-рт Цин Сы гэгчийн бичсэн нэгэн өгүүлэлд «Баатар Хунтайжийн хүү Галдан Зүүнгар аймгийн эрхийг булаан авсныхаа дараа Хаант Оросын ятгалга дэмжлэгээр Зүүнгар аймгийг хагалан бутаргагч хүчин болж ... үймээн дэгдээж манай улсын нэгдлийг эвдэх буюу угсаатнуудыг хагалан бутаргагч харгис хүчин болон хувирав Чин улсаас өмнө Зүүнгарт гарсан удаа дараагийн үймээн бол цөм л Хаант Оросоос Хятад улс руу түрэмгийлсэн явдалтай нягт холбоотой», «Галдан, Цэвээн равдан, Амарсанаа тэргүүтэй Зүүнгарын өчүүхэн бүлэг язгууртнууд, манай улсын баруун хойт нутагт тасархай оршин сууж, угсаатнуудыг хагалан бутаргах хүчний төлөөлөгчид болж байв. Тэд Хаант Оросын дэмжлэ-

* Х. Пэрлээ, Г. Сүхбаатар. Маогийнхан монголын түүхийг гуйвуулсаар байгаагийн үнэн учир-«ШУА-ийн мэдээ» 1976, No 3, 18-30-р тал.

О. Чулуун. Түүхийн хуудсыг эргэж сөхөхөд-«Маоизм маогийнхан» УБ., 1974, 91—112-р тал.

гээр хязгаар нутагт үймээн гаргаж...эх орноосоо урваж олон угсаатан ард түмэнд хор учруулан, улс гэрийн нэгдлийг сүрхий эвдэн сүйтгэж байвий, «Цэвээнравдан болон түүний хүү Галданцэрэн бас Хаант Оростой сүлбэлдэж үймээнийг хэвээр үргэлжлүүлж байв» гэх зэргээр XVII-XVIII зууны үед харь манжийн түрэмгийллийн эсрэг улс орныхоо дотоод нэгдэл, тусгаар тогтнолыг хадгалан хамгаалахын төлөө баруун монголчуудын хийсэн шударга тэмцлийг хятадын их гүрний дээрэнгүй үзлийн үүднээс мушгин гуйвуулсан байна. Эдгээр тэмцэгчид Манжийн байлдан дагуулагчдын эсрэг Хаант Орос улсын тухиралтаар тэмцсэн биш, харин үндэснийхээ эрх ашгийн үүднээс тэмцсэн бөгөөд тэд дайсны давуу хүчний өмнө хүчин мөхөсдөхөөр хөрш орны хувьд Орос улсаас тусламж эрж байсан боловч Хаант Оросын засгийн газар шийдвэрлэх тусламж өгөөгүй билээ.²

Бидний дээр дурдсан сэтгүүлийн мөн дугаарт «Худал үг түүхийг өөрчилж чадахгүй» гэдэг бас нэг өгүүлэл хэвлэгджээ. Түүнд Манж Чин улс Ойрадын эсрэг дайнд орж байлдан эзэлсэн, Зүүн Монгол манжид эзлэгдэж эхлэхийн хамт ойрадууд өөрийн хаант улсыг байгуулж хагас зуу гаруй жил тусгаар тогтнолоо хадгалж байсан, ер нь ойрадууд Хятадаас тусгаар байсан гэдэг энэ бүхэн цөм «худал үг» гэж зарлаад «Зүүнгар аймаг угаасаа тусгаар тогтносон байгаагүй. Зүүнгар аймаг бол Хятадын төв эзэн хаант төрийн харъяат байсан. XVII зууны эхэнд ч бас л тийм байсан», «Зүүнгар аймаг болон манай улсын төв засгийн газрын хоорондын харилцаа нь нэг улсын доторхи орон нутаг нь төвдөө харъяалагддаг харилцаа байв», «Чин улсын засгийн газраас Зүүнгарын задлан бутаргах явууллагыг дарсан явдал бол Хятад улсын дотоод асуудал бөгөөд нэг улсаас нөгөө улсыг байлдан дагуулах явдлаас бүрэн ялгаатай юм» гэж их гүрний дээрэнгүй бодлогын үүднээс Монголын нэг хэсэг Ойрадын түүхийг эрээ цээргүй мушгин гуйвуулжээ. Энэ нь 1969 оны 10-р сарын 8-нд хэвлэгдсэн «БНХАУ-ын Гадаад Явдлын Яамны баримт бичиг» гэгчид «Балхаш нуурын зүүн ба өмнүүр оршдог Зүүнгар нь Хятадын нүүдэлчин аймаг ойрад монголчуудаас бүрддэг. Чин улсын Зүүнгарыг төвшитгөсөн нь Хятадын дотоод асуудал...» гэснийг лавшруулсан хэрэг мөн.

Монгол, Зөвлөлт болон олон улсын монголын түүх судлагчдын бүтээлд маогийнхны энэ гуйвуулалтыг үндсээр нь бүрэн няцаах хангалттай судлагаа дүгнэлт бий юм.³ Гэтэл маогийнхан түүнийг үл хайхран зөвлөлтийн түүхчдийг гүтгэн дайрахдаа: «... манай улсын Зүүнгар аймгийн түүхийн талаар үргэлжлэсэн том өгүүлэл ном зохиол хэвлүүлж байгаа нь» эрдэм шинжилгээний судалгааны ажил биш харин шинэ цагаан хааны социал-империализмын өргөтгөх бодлогод үйлчилж, манай улсын Синь цэян нутгийг түрэмгийлэх явдалдаа түүхэн баримт сэлт болгох зорилготой юм» гэж ор үндэсгүй бичжээ. Одоо үед ЗХУ, БНХАУ хоёрын чухам аль нь бусдын газар нутагт өнгөлзөж байгаа нь хэн бүхэнд ойлгомжтой билээ. Иймд маогийнхан бусдыг гүтгэх гээд өөрсдийнхөө үнэн дүрийг илтгэж байна. Тэдний түүхийг завхруулж байгаа нь газар нутгийн өнгөлзлөгтэйгээ шууд холбоотой учир түүхийн ухааныг хамгийн бүдүүлгээр гуйвуулан гүтгэж байна.

Хятадын түүхчид «Зүүнгарыг аймгийн нэр болгон бичсэн нь Ойрад Монголыг хэзээнээсээ Хятадын хэсэг байсан гэж бичиж байгаатай нь

2. Ш. Б. Чимитдоржиев. Взаимоотношения Монголии и России XVII—XVIII вв. М., 1978. с. 170—171.

3. Н. Ишжамц, Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. УБ., 1962.

Ш. Нацагдорж. Халхын түүх. УБ, 1963, «БНМАУ-ын түүх», дэд боть. УБ.

1968 гэх мэт олон зохиол.

адил үнэнд нийцэхгүй байна. Манж Чин улсын засгийн газар, Ойрад Зүүн гарын хаант улсыг хамтран цохиж, нутгий нь хувааж авах саналыг Хаант Оросын засгийн газарт 1731-1732 онд удаа дараа тавихад Оросын засгийн газар тухай бүр татгалзаж байжээ.⁴ Чин улс XVII зууны сүүлчээр Ар Монголыг эзлээд дараачийн ээлжинд Ойрадыг эзлэх дайнд бэлтгэж эхэлсэн бөгөөд олон жил түрэмгий дайн нөрөөд шууд амжилтанд хүрч чадахгүй болохоороо 1739 онд эзэлсэн Ар Монгол, эзлэгдээгүй Ойрадын хилийг Алтайн нуруугаар тогтоосон хэлэлцээрийг Зүүнгарын хаант улстай байгуулсан билээ.⁵

Эдгээр баримт Ойрад буюу Баруун Монгол нь манжид эзлэгдэхийн өмнө Хятадын харъяанд байгаагүй тусгаар тогтнолоо хадгалж байсныг нотлохын хамт хятадын маоист түүхчдийн бичсэнээс бидний иш татсан элдэв завхралыг бүрэн няцааж байна.

Монгол, Хятад хоёулаа манжийн ноёрхолд 200 гаруй жил байхдаа өөр өөрсдийнхөө төрийн тусгаар тогтнолыг сэргээхийн төлөө цуцалтгүй тэмцэж байсан юм. Нэн ялангуяа Манж Чин улсын ноёрхлын сүүл үед Хятадын газрын эзэд, хөрөнгөтний төлөөлөгчид төрийн хэрэгт идэвхтэй оролцож хүчээр хятадчилах «шинэ засгийн бодлого» гэгчийг хүчлэн явуулсан нь Ар, Өвөр Монгол даяар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөхөд хүргэснийг монголын түүхчид болон монголын шинэ түүхийг судлагч гадаадын эрдэмтэд бүх талаар нь судалж, аль хэдийн нотолсон билээ. Гэтэл Ши Да дээр дурдсан товхимолдоо: «Хаант Орос улс Гадаад Монголын «тусгаар тогтнолыг» өдөөн гаргаж, хилээ манай улсын цагаан хэрмийн хаяа хүртэл тэлэхийг оролдсон нь» гэдэг гарчгийн дотор монголчуудын үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцлийг үгүйсгэн завхруулахыг оролджээ.

1911 он буюу цагаагчин гахай жил Манж Чин гүрэн даяар өрнөсөн олон ястан угсаатны ард түмний тэмцлийн давын түрүүнд гүйцэтгэх нийтлэг зорилт нь Манж Чин улсын ноёрхлыг устган тусгаар тогтнолоо байлдан сэргээхэд чиглэж байсныг тухайн үеийн түүхийн баримтууд хөдлөшгүй нотолж байна.

Тэр үед Монгол орон Манж Чин улсын улс төрийн ноёрхол, Хятадын эдийн засгийн мөлжлөгт нэрвэгдэж байсан тул Монголын үндэсний эрх чөлөөний тэмцэл нь манж хятадын ноёрхлын эсрэг шууд чиглэж байсан юм. Үүнд хөрш, хувьсгалт хөдөлгөөний төв болж байсан. Орос, Манж Чин улсын эрхшээлд байсан олон ястан угсаатан ард түмний эрх чөлөө ний хөдөлгөөнд нөлөөлсөн нь дамжиггүй. Гэтэл зохиогч монгол дахь ард түмэн хөдөлгөгч хүч нь болж байсан үндэсний эрх чөлөөний тэмцлийг тас үгүйсгэж бичихдээ: «Цагаагчин гахай жилийн хувьсгал дөнгөж өрнөж байхад, Оросын хаант засаг Монголын цөөн ван гүн нараар 1911 оны 12-р сард Гадаад Монголын «тусгаар тогтнолыг» тунхаглуулсан» гэжээ. 1972 онд Бээжинд хэвлэсэн бөгөөд дэлхий дахинд шуугиан дэгдээсэн «Дэлхийн атлас»-ын анхдугаар хэвлэлд* «Гадаад Монгол 1911 онд Хаант Оросын өдөөн хатгалтаар «Автономи тунхагласан» гэж бичсэн бөгөөд 1921 оны ардын хувьсгалын тухай юу ч дурдаагүй юм. Гэтэл 1974 онд хэвлэгдсэн

4 И. Я. Златкин. Очерки новой и новейшей истории Монголии. М., 1957, 77— 78-р тал.

5. Вэй Юань. Шэн у цзи. (Богд баатруудын тухай тэмээглэл) 3-р дэвтэр.

* Энэ атласын БНМАУ-ын тухай бичсэн тайлбарыг шүүмжилсэн дараахь өгүүлүүд манайд хэвэгдсэн: 1.

Н.Дагдан. Маогийнхны хэвлэсэн дэлхийн газрын зургийн утга учир-«Маоизм-Маогийнхан» 1974, 116—120-р тал; 2. Ж. Лхам. Их гүрний дээрэнгүй бодлогын бас нэг илрэл. «Үнэн» сонин, 1972-IX-17; 3. Л.Жамсран. Манж Чин улс шинэ засгийн бодлого гэгчээ Монголд хэрэгжүүлэх гэсэн нь» Түүхийн судлал 1975. 83-104-р тал.

мөнхүү «Дэлхийн атлас»-ын 3-р хэвлэлд «Гадаад Монгол 1911 онд Хаант Оросын өдөөн хатгалгаар «Автономи тунхагласан» гэдэг өгүүлбэрийг хасаад «1921 онд Монгол ардын хувьсгал ялж хэмжээг эрхт хаант засаг байгуулсан» гэж бичсэн нь маоист түүхчид манай эх орны түүхийг дураараа гуйвуулахаасаа зарим талаар татгалзаж, түүхэн үнэнийг дурдахаас өөр аргагүй болсныг харуулж байна. Ши Да хэдүйгээр монголчууд өөрсдөө тусгаар тогтнолоо тунхагласан гэдгийг үгүйсгэж байгаа боловч энд «автономи» биш «тусгаар тогтнол» гэдэг нэр томъёог хэрэглэсэн байна. «Тусгаар тогтнол» гэсэн үгийг хэрэглэснээрээ түүхэн үнэн рүү нилээд ойртсон байна.

Монгол даяар өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний явцад түүний гол удирдагч Ханддорж нарын оролцоотой байгуулагдсан «Халхын Хүрээний хэргийг Түр Ерөнхийлөн Шийтгэх Газар» нь ар, өвөр монголчуудыг Манж Чин улсын ноёрхлын эсрэг зэвсэгт тэмцэлд зохион байгуулж босгох ажлыг шуурхайлан хийж байлаа. Тэгэхдээ юуны урьд Монголын үндэсний эрх чөлөөний төв-Хүрээн дэх манж захиргааг хөөн зайлуулахын тулд Түшээт хан аймгийн хошуудаас 500 орчим цэрэг дайчлан ирүүлээд 11-р сарын 30-нд манж сайдыг монгол нутгаас даруй зайлахыг шаардахын зэрэгцээгээр Монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээн мандуулах тухай ухуулан зарласан бичиг гаргаж «...Манай монгол болбаас угтаа тусгай нэгэн улс мөн тул одоо хуучин журмаар, өөрсдөө улс болон өөрийнхөө хэргийн эрхээ бусдаар эдлүүлэхгүй, шинэ төр байгуулан тогтоохоор зөвлөн тогтсон»⁶ гэж мэдэгдсэн байна. Үүнээс хэд хоногийн дараа Монголын шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтыг Монгол улсын хаанаар өргөмжилж үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч Ар, Өвөр Монголын зүтгэлтнүүдээс бүрэлдсэн засгийн газар байгуулсан билээ. Тэгээд тэр засгийн газрын удирдлагаар Ар, Өвөр, Баруун Монголын нутгийг Чин улсын захиргаанаас чөлөөлөх тэмцэл явагдаж 1912 оны намар болоход Ар Монголын бүх нутгийг чөлөөлсөн бөгөөд энэ тэмцэлд өвөр монголчуудаас бас оролцож байсан юм. Түүхэн сурвалж баримтыг нягтлан үзэхэд 1911 онд Монголд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эхний шатанд буюу 1912 оны намар хүртэлх хугацаанд Манж Чин улсын ноёрхлыг устгаж үндэсний улсаа шашин төрийг хослон барьсан хаант засгийн хэлбэрээр сэргээж, түүний хяналтанд Чин улсын захиргаан дахь бүх монголчуудыг оруулах явдал тэмцлийн тэргүүн зэргийн зорилт болж байв. Энэ хөдөлгөөн харийн ноёрхлыг устгаж, үндэсний тусгаар тогтносон улсаа сэргээн байгуулах зорилттой байсны хувьд зарим талаараа үндэсний эрх чөлөөний хувьсгалын шинжтэй байв. Иймээс В. И. Ленин 1912 оны эхээр. Оросын Ажилчны Социал-Демократ Намын VI бага хуралд оруулсан нэг тогтоолын төсөлдөө, эрх чөлөөний хувьсгалт тэмцэл хийж байгаа Азийн ард түмнүүдийн тоонд Монголыг оруулж бичсэн байдаг.⁷ Чин улсын төр, Монголд байсан түүний захиргаа нэгэнт мөхсөний дараа 1912 оны сүүлчийн хагасаас Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хоёр дахь шатанд тэмцлийн гол зорилт нь Хмард Хятадын цэргийн эрхтний засгийн газар, мөхсөн Чин улсын оронд Монголыг ноёрхохын тул Өвөр Монголд хийж эхлэсэн түрэмгийллийг няцааж, нутаг орноо чөлөөлөхөд оршиж байлаа. Энэ шатны тэмцэл нь 1912 оны 3-р сард Өвөр Монголын Жирэмийн чуулганы Хорчин баруун гарын өмнөд хошуунд засаг ноён Удайн удирдлагаар гарсан зэвсэгт бослогоор эхлэсэн юм. Ар, Өвөр Монголд хамтарсан чөлөөлөгч цэрэг хятадын түрэмгийлэгчидтэй амжилт-

6. Улсын Түүхийн Төв Архив. (УТТА) ф. 1, ХН. 8.

7. В. И. Ленин. Зохиолууд. 17-р боть, 453—454-р тал.

тай тулалдан Монголын язгуурын нутгийн өмнөд хэсгийг чөлөөлж байсан нь тэр үеийн Монголын улс төрийн амьдрал дахь чухал үйл явдал мөн. Хаант Оросын засгийн газар Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг зөвхөн Халхын дөрвөн аймаг буюу Ар Монголын хүрээнд дэмжиж байсан бөгөөд харин уг хөдөлгөөн Ар Монголын хэмжээнээс хальж, гүнзгийрэх шатандаа шилжмэгц 1912 оны сүүлчийн хагаст Монголын засгийн газартай хэлэлцээ хийж, Монголын бүрэн тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн, хятадын эрх баригчдад буулт хийж зөвхөн Ар Монголд «Автономи» эрх олгохыг зөвшөөрч, Өвөр Монголыг чөлөөлөхийн төлөө байлдаж буй цэрэгт зэвсэг нийлүүлэхээсээ татгалзсан хийгээд Хүрээний засгийн газар ч арга буюу 1913 оны сүүлчээр Өвөр Монголоос цэргээ татахад хүрсэн юм.

Түүхэн бодит баримт ийм байхад зохиогч «Хаант Орос улс Гадаад Монголын тусгаар тогтнолыг өдөөн гаргаж хилээ манай улсын Цагаан хэрмийн хаяа хүртэл тэлэхийг оролдсон» гэж түүхийг завхруулж байна.

Хятад улсын засгийн эрхийг авсан Юань Ши-кай тэргүүтэй цэргийн эрхтнүүд олон улсын харгис хүчний дэмжлэгтэйгээр хятадын хөрөнгөтний хувьсгалыг цус урсган дарж, Монголын тусгаар тогтнолыг цуцалж, эзлэн түрэмгийлэх бодлогоо нэн идэвхжүүлэн 1913 оны эцсээс хүчлэн тэмцсэн юм.

Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг Оросын хаант засаг хэдийгээр өөрийн явцуу ашиг сонирхлын үүднээс зарим талаар дэмжиж байсан нь эцсийн эцэст Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийн ашиг сонирхолтой нийцэж байсан юм. Гэтэл тухайн үед Оросын хаант засаг нь өөрөө хүч сул ба нөгөө талаар хятадын шахалт зэрэг шалтгаанаас Монголын тусгаар тогтнолыг тууштай дэмжих боломжгүй байжээ. Иймээс Монголын ард түмний 1911—1913 оны эрх чөлөөний хөдөлгөөний өмнөө тавьсан зорилго гүйцэд биелэгдээгүй бөгөөд үүний гол буруутан нь тэр үеийн хятадын цэргийн эрхтэн болно.

1911—1913 оны Монгол дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн бол гадны хүчээр гарсан зохиогдмол зүйл биш бөгөөд эрх чөлөөний хөдөлгөөний дотоод зүй тогтлын дагуу үүсч гарсан болохын дээр харин ард түмний дийлэнх олонхид нь уг хөдөлгөөндөө оросыг түшиглэх хандлага маш хүчтэй байсан билээ. Монголын ард түмний хувьсгалт хөдөлгөөний уламжлалыг үгүйсгэж түүнийг зөвхөн. Хаант Оросын гараар хийгдсэн мэтээр үзэх нь түүхийн үнэн байдалд нийцэхгүй нь мэдээж юм.

Монгол нь Чин улсын ноёрхлын шувтаргаар империалист гүрнүүдийн нөлөөний хүрээнд хуваарилагдсан тул Монголын асуудал бол олон улсын чанартай болсон билээ. Иймд Хятадын засгийн газар Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нийтэд нь Хятадын хувьсгал шиг шууд цус урсган дарж болохгүй учир Монголыг нөлөөнийхөө хүрээнд хуваарилсан империалист гүрнүүдтэй дипломат шугамаар сүлбэлдэн тохиролцох явууллага хийсэн онцлогтой. Харин Оросын засгийн газар өөрийнхөө нөлөөний хүрээн дэх Ар Монгол, Баргыг Хятадын бүрэн ноёрхолд оруулахгүйг хичээсний дүнд, Ар Монгол нь 1915 оны 6-р сард Хятад, Оросын засгийн газраас Монголд тулгаж байгуулсан гурван улсын хэлэлцээр гэгчээр Хятадын автономит улс, Барга мөн оны 11-р сард байгуулсан Хятад-Оросын хэлэлцээр гэгчээр Хятадын тусгай район буюу автономит район болж тус тус таслагдсанаас гадна, Хятадын засгийн газар Японы 21 зүйлийн шаардлагаар Өвөр Монголын дорнод хэсгийг түүнд эзэмшүүлэхээр нууц тохиролцсон юм. Ийнхүү Хятадын цэргийн эрхтний засгийн газар монголчуудын хүсэл эрмэлзлэлээс гадуур олон улсын харгис хүчин-

тэй үгсэж тохиролцох замаар хязгаарлагдмал, нэрийн төдий эзэн эрх (Сюзеренитет)-ийг Монголын хувьд анх удаа олж авсан юм.

Октябрийн социалист их хувьсгалын ялалтын дүнд тогтсон Зөвлөлт засгийн газар, урьд Хаант засгийн газраас бусад орныг колоничлох зорилгоор байгуулсан эрх тэгш биш бүх гэрээ хэлэлцээрийг цуцлалсныг далимдуулан хятадын цэргийн эрхтнүүд «большевизмын аюулаас сэрэмжлэх» нэрийдлээр Ар Монгол, Баргын автономийг 1919-1920 онд тус тус устгаж, зэвсгийн хүчээр эзэлсэн юм.

ХКН-ын хэвлэл «Цзефан жибао» сонин энэ тухай 1945 оны 10-р сарын 29-нд бичихдээ» «...Монголын ард түмэн аль эрт тусгаар тогтнох хүсэл эрмэлзлэлтэй байсан бөгөөд 1911 онд тусгаар тогтнолоо тунхагласан билээ. Хойт хятадын цэргийн эрхтний засгийн газар, Манжаас гадаад Монголд явуулж байсан бодлогыг залгамжлан авч, их хятад үндэсний үзлийг баримтлан гадаад Монголыг зэвсгийн хүчээр нэгтгэхийг оролдсон боловч 1921 онд Гадаад Монголын ард түмэн хоёр дахь удаагаа тусгаар тогтнолоо тунхагласан юм» гэж байв. Үнэн байдал ийм байхад Ши Да Монголыг эзлэн ноёрхохын төлөө империалист гүрнүүд болон Хятадын цэргийн эрхтний засгийн газрын хооронд болсон өрсөлдөөн, тэмцэлд хятадын засгийн газар бүрэн ялж чадаагүй нь гагцхүү Хаант Орос улсаас болсон гэдгийг нотлох гэж товхимолдоо их оролджээ. Хятадын засгийн газрын олж авсан Монголыг ноёрхох «эзэн эрх» гэгч нь тэр үедээ ч нэрийн төдий байсан, одоо бол бүр ч авч хэлэлцэх үндэсгүй болох нь хэн бүхэд ойлгомжтой. Монголчууд өөрийн биеэ даасан төр, эдийн засаг, соёл иргэншлийн уламжлалаа хадгалсаар ирсэн нь Монгол орон хэзээнээсээ Хятадын хэсэг байгаагүйг нотолж буй хамгийн бодит баримт мөн. Ши Да товхимолдоо: «Октябрийн хувьсгалын дараа, Ленин тэргүүтэй Зөвлөлт засгийн газар, Орос улсын удаа дараагийн засгийн газар Хятадад тулган хүлээлгэж байгуулсан эрх тэгш биш гэрээг хүчингүй болгож, Хаант Оросын Хятадаас олж авсан бүх онцгой эрхийг хэрэгсэхгүйгээ албан ёсоор тунхагласан юм. Гэтэл тэр үеийн түүхэн нөхцлийн улмаас Лениний энэхүү пролетари ангийн бодлого хэрэгжиж чадаагүй юм» (79-р талд) гэж бичсэнээр их Лениний нэрийг барья: манай орны хувьд Хятадын их гүрний дээрэнгүй үзэлтнүүдийн хийж буй өнгөлзлөгийг зөвтгөхийг оролдож байна. Үүнд В. И. Ленин тэргүүтэй Зөвлөлт засгийн газраас 1918 онд Монгол үндэсний олон аймаг ба Автономит Монголын засгийн газарт илгээсэн тунхаг бичгээс иш татах хэрэгтэй болж байна. Түүнд өгүүлэхдээ: «Оросын ард түмэн Монголын тухай Япон, Дундад хоёр улстай, урьд хааны үед тогтоосон аливаа гэрээ зүйлийг цөм устгасны учир, үүнээс хойш Монгол улс бол өөртөө эрхт тусгаар нэгэн орон мөн ...Монголын дотоод хэрэгт ямар ч гадаадын хүн оролцох эрхгүй...Монгол улс тусгаар тогтносон орны ёсоор Бээжин, Петроград хоёроос асуулгүй, аливаа олон улстай шууд харилцан нэвтрэлцэх эрхтэй болсон явдлыг манай Зөвлөлт засгийн газраас монгол үндэсний улсад чухам мэдэгдэн тунхаглахын хамт манай орос улстай даруй харилцан нэвтрэлдэж элчин явуулан эрх чөлөөт Монгол улсын төлөөний хүмүүсийг манай улаан цэргийн өмнөөс тосон илгээх ажаамуу»⁸ гэсэн юм.

Үүнээс үзэхэд орон бүхний пролетари нарын их удирдагч В. И. Ленин түүний байгуулсан Зөвлөлт засгийн газар Орос, Хятадын их гүрний дээрэнгүй бодлогыг дэмжиж байгаагүй, харин Монгол ард түмний өөрөө засан тохинох эрхийг тууштай өмгөөлөгч байсан нь илэрхий.

Маогийнхан ийнхүү монголчуудын үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө харийн түрэмгийлэгчидтэй эвлэршгүй тэмцэж ирсэн яруу алдарт баатарлаг тэмцлийг элдвээр завхаруулан үгүйсгэж байгаагийн учир нь юуны урьд, Манжийн байлдан дагууллын улмаас Хятадын харьяанд үлдсэн бөгөөд одоо БНХАУ-д үндэстний болон иргэний ямар ч эрх мэдэлгүй хавчигдаж, үндэсний хувьд мөхөх аюулд нэрвэгдэж буй Өвөр Монголын ард түмний үндэсний ухамсрыг төөрөлдүүлэхэд чиглэж байна. Нөгөө талаар манай орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрт өнгөлзөх «түүхэн үндэс» бүрэлдүүлэх, ЗХУ-ыг хуучин оросын Хаант засгийн түрэмгий бодлогыг үргэлжлүүлэгч, «хэт их гүрэн» болсон гэж гүтгэх хорт санаа агуулж байна.

III

Ардын хувьсгалын ялалтын дүнд Ар Монгол тусгаар тогтносон үеэс эхлэн монгол-хятадын ард түмний хооронд ангийн эв санааны нэгдэл дээр тулгуурласан шинэ маягийн харилцаа үүсч хөгжих төлөв нээгдсэн билээ. МАХН-ын удирдлагаар БНМАУ-ын хөдөлмөрчид үндэсний ба нийгмийн эрх чөлөөний төлөө хятадын ард түмний олон жил хийсэн шаргуу тэмцлийг бололцооныхоо хирээр дэмжин туслаж байв. Хятадад ардын хувьсгал ялж, БНХАУ-ыг байгуулахад манай ард түмэн туйлын баяртай угтаж социалист бусад орнуудын нэгэн адил БНХАУ-ын ардын төв засгийн газрыг хүлээн зөвшөөрөхдөө, монгол-хятадын ард түмний хооронд жинхэнэ ах дүүсэг найрамдал, хамтын ажиллагаа үүсч хоёр орны ард түмний тусын тулд улам хөгжинө гэж итгэж байсан юм. Төдхөн эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээрүүд, найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ байгуулагдаж тэдгээрийн дагуу тус хоёр орон улс төр, эдийн засаг, соёлын зэрэг олон салбарт өрнүүн хамтран ажиллаж эхэлсэн билээ. Гэтэл Хятадын эрх баригчид манай орны хувьд хоёр нүүрт бодлого явуулж байв. Энэ нь тэд нэг талаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг бусад оронтой сэм үгсэн тохиролцох замаар буюу Юань Ши-кайн аргаар цуцлаж Хятадад нэгтгэх, нөгөө талаар өөрсдийгөө монголын ард түмний хөгжил цэцэглэлтийн төлөө хосгүй санаа тавьж туслагчийн дүр үзүүлэн монголчуудыг эеэр татаж тэдний дундаас хятадын бодлогыг бишрэн дагагчдыг бий болгох замаар буюу Хятадын эзэн хаадын аргаар БНМАУ-ыг Хятадад нэгтгэх оролдлого хийж байсан явдал юм.

Гэтэл маогийнхны тийм оролдлого нь социалист орнуудын хоорондын харилцааны зарчим хийгээд монголын ард түмний эрх ашигт харш учир хэрэгжиж чадаагүй юм. Харин МАХН-ын зөв удирдлага, алсын хараатай тууштай бодлогын ачаар БНМАУ-ын байр суурь дэлхийн социалист систем болон олон улсын харилцааны талбарт улам бэхжиж, маогийнхны уриханд орохгүй нь нэгэнт илэрхий болмогц, хятадын удирдлага БНМАУ-тай тогтоосон гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх явдлыг манай оронд өнгөлзөж байгаа эчнээ бодлого, Монгол-Зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааг тасалдуулах гэсэн санаархалдаа захируулахыг хичээх болсон юм. Мао Цзэ-дун энэ бүхнээ 1965 онд Японы социалист намын төлөөлөгчидтэй ярилцахдаа дэлгэж тавьсныг манай ард түмэн, хань нөхөд зүй ёсоор хилэгнэн эсэргүүцсэн билээ.

Маогийнхан 60-аад оноос эхлэн БНМАУ-ыг улс төр, эдийн засгийн талаар шахалт үзүүлэх, хорлон сүйтгэх элдэв явууллага хийхийн зэрэгцээгээр манай туулсан түүхэн замнал, монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааг гуйвуулж гүтгэсэн янз бүрийн мэдээ, өгүүлэл олон нийтлүүлэх болсон юм. Тэдгээрийн мөн чанар зорилгыг манай эрдэмтэд зохиогчид тухай бүрд нь илчлэн шүүмжилж няцаасаар ирсэн би-

лээ.* Гэтэл маогийнхан тэдгээрийг үл ойшоон манай орны нэн шинэ түүхийн олон чухал асуудлыг дур зоргоор гүтгэн гуйвуулдгаа улам гааруулж зөвлөлтийг эсэргүүцэх үзэл, манай орны төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрт өнгөлзөх явдалдаа «үндэслэл» болгохыг хичээж байна.

МАХН-ынхаа удирдлагаар ардын хувьсгалыг ялалтанд хүргэж, төрийн тусгаар тогтнолоо байлдан олоод улс орноо капиталист бус замаар хөгжүүлж социализмд дэвшсэн манай түүхэн туршлагыг «Ази, Африк, Латин Америкийн ард түмний эсрэг талын сургагч» «...зөвлөлтийн ревизионистуудын шинэ колоничлолын бодлогыг борлуулах ажил...»⁹ гэх зэргээр маогийнхан гүтгэж байна. Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааны шинж чанарыг гуйвуулахдаа: «БНМАУ бол ЗХУ-ын колони, цэргийн бааз», «ЗХУ БНМАУ-ыг цэргийн хүчээр эзлээд бүх талаар түрэмгийлэн мөлжиж байна» гэж тэд бас нотлохыг оролдож байна. Маогийнхны жанжлан ноёрхох гэсэн эрмэлзлэл, оролдлого бүхэнд гол саад нь дэлхийн ууган социалист хүчирхэг гүрэн-ЗХУ болж байгаа учраас Бээжингийн эрх баригчид түүний нэр хүндийг ямар ч гүжир гүтгэлэг бузар аргаар боловч гутаах гэж улайрсаар байна. Одоо хятадын суртал нэвтрүүлэг зогсоо зайгүй цоордож байгаа Мао Цзэ-дунгийн «гурван ертөнцийн онол» гэгч аанай л тийм зорилгоор гарч ирсэн билээ.

Капитализмыг алгасан социализмд дэвшсэн БНМАУ-ын туршлага бол колони, хараат орон байсан улс түмэнд үлгэр дууриалалтай юм. Иймээс маогийнхан БНМАУ-ын нэр хүндийг «гурав дахь ертөнцийн» орнуудын өмнө гутаахыг бүхий л аргаар оролдож байна. 1977 онд Бээжинд хэвлэгдсэн «Гурав дахь ертөнцийн үүсэл, хөгжил» гэдэг номыг зохиогчид манай орныг Зөвлөлт Холбоот Улсын колони гэж гүтгэхэд гол анхаарлаа тавьсан байна.

1972 оноос эхлэн Бээжинд хэвлэгдэх болсон «Дэлхийн атлас»-ын хэдэн удаагийн хэвлэлд манай орны тухай бичсэн тайлбар нь Монголын түүхийг гуйвуулахын зэрэгцээгээр «Гадаад Монгол бол уг нь манай улсын нэг хэсэг юм» гэж дахин давтан бичсэн явдал манай улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрт маогийнханы өнгөлздөгийн илрэл мөн.

БНМАУ, БНХАУ хоёр нь Ази ба даян дэлхийд энх тайвныг бэхжүүлж, улс түмний аюулгүй байдлыг хангах, тус тусын энх тайван бүтээн байгуулалтын үйлсэд техник-эдийн засгийн тусламж үзүүлэх, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэн хөгжүүлэхийг заасан найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ, хилийн тухай гэрээ болон бусад хэлэлцээрүүдээр хоорондоо харилцах үндсэн зарчмаа тодорхойлон тогтоосон билээ. Гэтэл хятадын эрх баригчид гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хөсөрдүүлж манай орны аюулгүй байдлыг шууд заналхийлж, Ази болон даян дэлхийн энх тайван, намжмал байдалд аюул учруулах болсон билээ.

БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-тай сайн хөршийн харилцаатай байхын тул өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийж ихээхэн чармайлт гаргасан боловч Хятадын тал хүлээж аваагүй учир, улс орныхоо аюулгүй байдлыг хангахын тул зөвлөлтийн цэргийн зарим ангиудыг монгол-зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээний дагуу

*«Хятад дахь хэрэг явдлын тухайд» 1, УБ., 1974. гэдэг эмхтгэлд тийм өгүүлэл олон орсон. Мөн О. Чулуун. БНМАУ ба БНХАУ-ын харилцааны асуудал. М. Дулам. Монгол-Зөвлөлтийн найрамдлыг таслах гэсэн явууллага-«Маоизм, Маогийнхан» УБ., 1974, 195-230-р тал, О. Чулуун, БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн туршлагыг маогийнхан гуйвуулж байгаа нь «Маоизм, Маогийнхан» УБ., 1976, No 2, 40—52-р г.м
9. «Жэньминь жибао» 1967, X. 27.

ирүүлж өөрийн нутагт байлгах болсон билээ. Энэ тухай БНМАУ-ын Засгийн газраас БНХАУ-ын Засгийн газарт 4-р сарын 12-нд өгсөн нотод заахдаа: «Зөвлөлтийн цэргийн ангиудыг Монголд одоо байлгаж байгаа учир шалтгаан нь Хятадын эрх баригчдаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талаар явуулж байгаа бодлогод л оршиж байгаа юм. Өөр шалтгаан байхгүй» гэжээ.

Манай улсын нутагт байгаа зөвлөлтийн цэргийн ангиуд нь бусад орныг огт заналхийлдэггүй бөгөөд БНМАУ-ын зэвсэгт хүчний хамт тус орны эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахын зэрэгцээ манай улс ардын аж ахуйн бүтээн байгуулалтанд асар их тусалж байгаа юм.

БНМАУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслалцах тухай 1960 оны гэрээний хоёрдугаар зүйлд: «Хэлэлцэн тохирогч хоёр тал нь БНМАУ болон БНХАУ-ын аль алины ашиг сонирхолд холбогдол бүхий олон улсын чухал асуудлаар харилцан зөвлөлдөж байна»¹⁰ гэж заасан юм. Гэтэл Хятадын тал гэрээний заалтыг шууд зөрчиж БНМАУ-ын нутгаас цэргийн ангиудаа гаргах шаардлагыг саяхан ЗХУ-д тавьсан нь Маог залгамжлагчид БНМАУ-ын бүрэн эрхт тусгаар тогтносон байдлыг үл тоомсорлон, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож, манай үнэнч холбоотон их хөрш ЗХУ-ыг эзлэн түрэмгийлэгч мэтээр үзэж байгаа хийгээд өөрсдөө БНМАУ-д өнгөлзөж байгаагаа дахин харууллаа. Хятадын их гүрний дээрэнгүй үзэлт эрх баригчид БНМАУ-ын тусгаар тогтнолд өнгөлзөхөөрөө асуудлыг ийнхүү манай ард түмний ар хударгаар тавьж шийдвэрлэхийг нэг биш удаа оролдож байсан билээ. Иймд хятадын эрх баригчдын энэ явууллагыг манай орны нийт хөдөлмөрчид болон шударга улс түмэн эсэргүүцсээр байна. Зөвлөлтийн цэргийн ангиудыг БНМАУ-ын нутгаас гаргах гэсэн шаардлагатай холбогдуулан БНХАУ-ын Засгийн газарт өгсөн манай засгийн газрын нотод: «Хятадын эрх баригчид Монгол улсыг булаан эзлэх эрмэлзлэлээ орхиогүйгээр үл барам, БНМАУ болон түүний холбоотон ЗСБНХУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлээ улам хүчтэй болгосоор байгаа учраас манай улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол заналхийлэх аюул хэвээр байна»¹¹ гэж дүгнэсэн нь бүрэн зөв байна.

Дээр дурдсанаас үзэхэд маогийнхан их гүрний жанжлах санаархлын үүднээс зохиож гаргасан «Хятад бол бүр 2000 гаруй жилийн тэргээ нэгдмэл олон угсаатны улс болсон...ямар ч угсаатан захирч байлаа гэсэн Хятад нь дэлхий дээр олон угсаатны улс хэвээр оршин тогтносоор ирсэн юм»¹² гэдэг хуурамч үндэслэлийнхээ үүднээс Монголын түүхийг гуйвуулж Хятадын хэсэг гэж үзэж байна.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятадын гоминьданы засгийн газар анх хүлээн зөвшөөрсөн юм. Хятадад хувьсгал ялж, БНХАУ байгуулагдахад БНМАУ-ын Засгийн газар, Хятадын. Ардын төв засгийн газрыг хүлээн зөвшөөрч улмаар дипломат харилцаа тогтоож найрамдал, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд чиглэсэн олон гэрээ хэлэлцээр байгуулсан билээ. Гэтэл маогийнхан манай улсыг өөрийнхөө хэсэг гэж шууд хараахан нэрлээгүй байгаа боловч өнгөлзөж байгаа санаархлаа янз бүрийн арга, хэлбэрээр илэрхийлсээр байна.

Гэвч монголчуудын өвөрмөц соёл иргэншил, төрийн уламжлалын түүхийг гуйвуулж, бүрэн эрхт тусгаар тогтносон социалист Монгол улс бодит оршин тогтнож байгааг үгүйсгэх тийм түүхийн баримт нотолгоог маогийнхан хаанаас ч хэзээ ч олж чадахгүй.

10. «БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл» I боть, УБ., 1964, 50-р тал.

11. «Үнэн» сонин, 1978-IV-13.

12. «Жэньминь жибао», 1969-X-8,

О ФАЛЬСИФИКАЦИИ ИСТОРИИ МОНГОЛИИ В НЕКОТОРЫХ ПОСЛЕДНИХ ТРУДАХ КИТАЙСКИХ ИСТОРИКОВ

М. Дулам

Резюме

О том, как китайские маоистские историки, начиная с 60-х годов, умышленно начали фальсифицировать узловые проблемы истории Монголии, уже писалось в наших научных работах.

Автор данной статьи подвергает научной критике маоистскую интерпретацию ряда важнейших проблем истории Монголии нашедшую своё отражение в китайских изданиях, вышедших за последнее время (в статьях, напечатанных в журнале «Лиши яньцзю», «Атласе мира», Краткой истории агрессии Царской России в Китае», «Возникновении и развитии третьем го мира» и др).

Китайские историки, полностью отрицая историю самостоятельного политического и государственного развития кочевых народов, в том числе и монгольского народа, всячески пытаются доказать, что Монголия издавна является частью Китая. Касаясь вопросов истории Монголии в период маньчжурского владычества, китайские историки извращают историю национально-освободительного движения монгольского народа. Они всячески оправдывая и идеализируя маньчжурское господство в Китае и Монголии, в корне отрицают освободительную миссию национально-освободительного движения монгольского народа 1911— 1913 гг. По утверждению китайских историков, провозглашение независимости Монголии в результате этой борьбы является реакционным явлением, направленным против единства Китая и прошедший по указке Царской России.

Исходя с традиционной синецентристской концепции китайских правителей, современные китайские историки рассматривают отношения Китая с Монголией на разных этапах истории, как типичные отношения между сюзереном Китаем и вассалами-варварами. Однако, эти отношения представляют собой отношения между двумя разными странами и государствами.

Хотя китайские историки не осмеливаются игнорировать существование независимой социалистической МНР, они всячески пытаются опорочить великие завоевания нашего народа на пути некапиталистического развития и социалистического строительства. При этом они особенно стремятся облить грязью священную дружбу монгольского и советского народов, забывая о враждебной политике своего нынешнего руководства в отношении нашей страны,

В заключение автор пишет, что основная цель фальсификации истории Монголии заключается в «научном» обосновании гегемонистских устремлений пекинских лидеров и их великодержавной экспансионистской политики в отношении МНР.